

Эмэгтэй хүний дүр орчин үеийн монголын зарим зураачдын бүтээлд

Ш.Өрлөг*

Хөлөнбуйр Их Сургууль, Боловсролын сургууль,
Бага боловсролын тэнхим

Хураангуй

Хүн төрөлхтөн уран зургийн түүхэнд олон сэдвийг амилуулсаар ирсэн. Тэдгээрийн дундаас эмэгтэй хүнийг дүрслэх, ялангуяа эмэгтэй хүний гоо сайхныг магтан дуулах нь үе үеийн зураачдын гоо сайхныг илэрхийлэхийн нэгэн бэлгэ тэмдэг байсаар иржээ. Уран зургаар сайхныг илэрхийлэх, сайхныг бүсгүй хүнээр илэрхийлэх нь ямагт бийр будаг ихэрлүүлж зураг урлагийн түүхэн үеүдийг элээсээр эдүгээд хүрчээ.

Орчин үеийн уран зурагт эмэгтэй хүний гоо сайхныг дүрслэх академик хэв загвараас зайлсхийж, эмэгтэй хүний дотоод ертөнц, дотоод гоо сайхныг илэрхийлэн гаргахыг чухалчлах болжээ. Монголын орчин үеийн эмэгтэй зураачид уран зураг дахь эмэгтэй хүнийг дүрслэх хэв маягт шинэ алхмыг хийж, сэтгэлгээ, арга барилын хувьд өвөрмөц өнгө аясыг бүтээх тал дээр амжилтыг олж яваа бөгөөд энэ нь эрэгтэй зураачдын дүрсэлдэг эмэгтэй хүний дүр дүрслэлээс ихэд өвөрмөц ялгаатай, илүү дотоод ертөнцийг харуулсан сэтгэлгээний өнгө аястай байж, уран зураг дахь эмэгтэй хүний гоо сайхны дүрслэлд өвөрмөц өнгө аясыг нэмж байна.

Түлхүүр үг

Уран зураг, уламжлалт зураг, гоо сайхан, дүр дүрслэл, эмэгтэй зураачид, арга билэг

Удиртгал

Хүн төрөлхтөн эртнээс нааш эрэгтэй хүнийг аргын бэлгэдэл, эмэгтэй хүнийг билгийн бэлгэдэл болгон үлгэр туульстаа уламжилсаар ирсэн. Арга буюу эр хүн хүч чадал, эр зоригийг илэрхийлдэг бол билэг буюу эм хүн гоо сайхан, цэвэр ариуныг бэлгэддэг нийтлэг шинж байдаг. Тиймээс гоо сайхны бэлгэдэл болсон эмэгтэй хүний дүрс дүрслэл балар эртнээс өнөөг хүртэлх хүн төрөлхтний үе үеийн урлаг соёлын зүйлд маш элбэг тохиолддог билээ.

Улс үндэстэн бүрийн гоо сайхны таашаал, үнэлэмж нь тухайн ард түмний ертөнцийг үзэх үзэл, соёл уламжлал, аж амьдралын хэв маяг, байгаль орчин, цаг уур, бие махбодын онцлогоос хамааран өөр өөрийн онцлогтой байдаг. Монголчуудын гоо сайхан эмэгтэйд магтан дуулсан дүрслэл уран зохиол болон дүрслэх урлагт хамгийн түгээмэл тохиолддог. Энэхүү өгүүлэлд бид хүн төрөлхтний зураг дүрслэл дэх гоо сайхныг илэрхийлэх олон дүр тэмдгийн дотор эмэгтэй хүний дүр дүрслэл онцгой байр суурь эзэлж ирсэн уламжлалд үндэслэн орчин цагийн уран зурагт эмэгтэй хүний гоо сайхныг дүрслэх уламжлал нь хэлбэрийн гоо сайхнаас дотоод гоо айхныг илэрхийлэх сэтгэлгээний хандлагатай болж хөгжиж буйг тодруулахыг зорьсон болно.

Судлагдсан байдал

Эмэгтэй хүний дүрийг урлаж үлдээсэн хамгийн эртний дүрслэх урлагийн бүтээл бол хадны зураг юм. Хадны зурагт эмэгтэй хүнийг ихэвчлэн овгийн ахлагч, өсөж үржихийн бэлгэдэл гэдэг талаас нь дүрсэлж байсан нь хүний нийгэмд эхийн эрхт ёс ноёрхож байсантай холбоотой. Жирэмсэн, амаржиж байгаа, хүүхдээ хөтөлсөн эмэгтэйн дүрслэл шинэ чулуун зэвсгийн үеийн хадны зурагт олон тохиолдоно. Ингэхдээ эмэгтэй хүний эрэгтэй хүнээс ялгагдах гол онцлог болох хөх, бэлгэ эрхтнийг нь онцлон тодруулсан байдаг. Монголын нэрт эрдэмтэн, хадан зургийн судлаач Т.Санжмятав "...Хүнийг дүрслээд аарцаг дор нь цэг буюу толбо тэмдэглэсэн нь хүүхэд төрөхийг бэлгэдсэн хэрэг бөгөөд эмэгтэй хүн гэж таниулахын тулд билиг тус газар тэмдэг тавьсан байдаг" (Санжмятав, 1995, х.18) тухай тэмдэглэсэн буй. Мөн урлаг судлаач Н.Цүлтэм Архангай аймгийн Чулуут голын эргээр олдсон хадны зурагт толгой дээрээ эвэртэй марал эх тэргүүтэн эхнэрүүд хүүхэд төрүүлж буй нэлээд хийсвэр дүрслэлээр жишээ авч, "Өнөр эх, Холонц эмгийг ихэвчлэн өвдгөөрөө нугалсан хоёр хөлөө хол алцайсан дөрвөлжин суурьтай байдлаар эгц өмнөөс нь дүрсэлж, хөл гарыг шувууны сарвуу мэт гурван салаатайгаар зурсан байдаг нь дүрслэлийн хувьд ихэд тоймлог геометр

*Холбоо барих зохиогч:276261579@qq.com

загварчлалыг ашигласны дээр, мөн тэдний Холонц гарвал сүнсний жигүүртэн шувуудтай холбоотойг үзүүлсэн байж болно” (Цүлтэм, 1988, х.8) гэж судалгаандаа онцолсон байдаг.

Ер нь балар эртний үед эмэгтэй хүнийг өсөж үржихүйн бэлгэдэл болгосон домгийн сэтгэлгээний, хийсвэр дүрслэл Монгол нутгийн хадан зурагт элбэг тохиолддог. Үүнээс эмэгтэй хүн гэр бүл, овог отогтоо хүндлэл хүлээх, өндөр байр суурь эзлэх үнэлэмжид түүний нөхөн үржихүйн чадвар онцгой ач холбогдолтой байсныг ойлгож болно. Монголчуудын үүсэл гарлын тухай домгийн санааг агуулсан холбогдох Холонц эх, Марал бугын дүрслэл болон эм хүйсийг нэн хийсвэрлэсэн гурвалжин, ташуу дөрвөлжин дүрс дүрслэлүүд (Цүлтэм, 1988, х.7) хүрлийн үеийн хадны зураг болон эд хэрэглэлд элбэг тохиолддог нь тухайн үеийн хүмүүст эм хүйсийг тэмдэглэх, эмэгтэй хүнийг дүрслэх хийсвэр дүрслэлийн хэлбэр, түүнийг таньж мэдэх нийтлэг ойлголт тогтоод байсныг илтгэнэ. Энэ бол хүний нийгмийн нэн эртний түүх, тухайн үеийн хүмүүсийн гоо сайхны таашаал, уран сайхны сэтгэлгээний хэв маяг юм.

Хүн төрөлхтний гоо сайхны таашаал, үзэл бодол, ухамсар сэтгэлгээ, уран сайхны хөгжлийн зохих түвшинд хүрээд уран зурагт эмэгтэй хүнийг дүрслэх огт өөр хэв маяг бий болсон нь бодит дүрслэлийн хэлбэр юм. Бодит дүрслэлийн арга хэлбэр дээд цэгтээ хүрсэн сэргэн мандалтын үед эмэгтэйчүүдийн гоо сайхныг үнэлэх үнэлэмж нь уран зурагт хамгийн тодоор илэрсэн байдаг. Булбарай зөөлөн арьс, зузаан бумбагар ташаа гуя, нарийн гоолиг бэлхүүс, уян налархай хөдөлгөөн, урт сайхан гэзэг нь тухайн цаг үеийн сайхан эмэгтэйн нийтлэг төрх байж, уран зурагт үлджээ. Да Винчи, Рубенс, Ренуар гээд дэлхийн сонгодог уран зураачдын сор бүтээлүүдэд эмэгтэй хүний гадаад гоо сайхан маш уран тансгаар мөнхрөн үлдсэн. Эмэгтэй хүний гоо сайхныг ойлгож дүрслэх энэ хэв маяг нь уран зурагт бодит дүрслэлийн адил урт настай байж, хүн төрөлхтний уран зургийн олон зууны түүхэнд оршсоор ирсэн юм. XIX зууны сүүл хагасаас “Уламжлалт гоо зүй, уран сайхны сэтгэлгээний хүрээнд арга барилын шинэ шийдэл гаргаж, зөвхөн бодит төдийгүй, бодит бус дүрсүүдээр зохиомжийг бүтээх, цэвэр өнгө болон өнгийн хувьсал, тэдгээрийн хоорондын харьцаагаар бүтээлийн хэмнэл ба орон зайг алслалт хэрэглэхгүйгээр гаргах зэрэг шинэлэг шийдлүүдийг нэвтрүүлснээрээ онцлог” (Уранчимэг, 2002, х.7) тодорч иржээ.

Орчин үеийн уран зураачид эмэгтэй хүнийг зурахдаа толигор арьс, булбарай царай,

галбирлаг бие зэрэг гадаад гоо сайхныг төдий л чухалчлахгүй болж. Түүний оронд эмэгтэй хүний сэтгэлийн нарийн хөг аяс, дотоод ертөнцийн будлиант байдлыг торгон мэдрэмжээр илэрхийлэхийг эрмэлзэх болжээ. Эмэгтэй хүний дотоод ертөнцийн гоо сайхныг уран нарийнаар мэдэрч гаргах тал дээр эмэгтэй зураачид илүү амжилттай явна. Энэ нь аргагүй эрэгтэй, эмэгтэй хүний бие, физиологи, сэтгэлзүйн онцлогоос хамааралтай биз ээ.

Судалгааны арга зүй

Уран зурагт эмэгтэй хүний гоо сайхныг дүрсэлж ирсэн онцлогийг судлахдаа бид зураг дүрслэлийн түүхэн хөгжлийн хэлхээнд түшиглэн, тэдгээрийн дүрслэлийн хэл хэллэгийг харьцуулсны үндсэн дээр уран сайхны хэтрүүлгээр дамжин илрэх утга бэлгэдийг психо-аналитикын аргаар задлан түүний далд онжид санааг тодруулан гаргав.

Судалгааны үр дүн

Амьдралын үнэнээс, эд эс бүхнээс санаа сэдлийн үр олж ухаарсан, зүрх сэтгэлээрээ мэдэрсэн уран бүтээлч л урлагийг бүтээж чаддаг. Цэг тавиад ч юм уу, зураас татаад л, аль эсвэл ганц нэгэн өнгө тавихад л ямар нэгэн юм хэлчихэж болдог уран зураг бодитоос ангижрах боломжоор бусад урлагаас хавьгүй илүү ажээ.

Зураач Б.Хонгорзул “Цагаан эрвээхэй” бүтээлдээ эрвээхэйн даль бүхий нүцгэн бүсгүйг дүрслэн харуулжээ. Эрвээхэйн даль нь ямар нэг хээ, өнгө будаггүй, тун ч даруухан байгаа нь эгэл нэгэн эмэгтэйд дүрсэлсний илрэл бололтой. Дөрвөн далавчийг хатгуур зүүгээр тэлж, ямар нэгэн зүйлд татсан ба даль нь зарим хэсгээрээ сэмэрч элэгдсэн харагдана. Эмэгтэйн царай төрх, нүцгэн биеэс гоо сайхан гэхээсээ илүү ядарч зүдэрсэн, гундуу байдал мэдрэгдэнэ. Жирийн нэг тэр бүсгүй амьдралд хэтэрхий нухлагджээ. Хатуу хүтүү амьдралыг үүрч дүүрч байгааг далины сэмэрсэн байдал, өнгө будаггүй төрх нь илтгэн харуулна. Өр өвдөм эмзэг турьхан байдал, амьдралд нухлагдаж туйлдсан, өдөр хоногуудыг ядуухан элээж яваа гунигт дүр төрх энэ зургаас мэдрэгдэж, сэтгэлийн эмзэглэл төрүүлэх юм. Энэ зургаас эмэгтэй хүн эрвээхэй мэт гоёмсог гэх оргилом дэврүүн хүсэл сэтгэл бус харин, эрвээхэй мэт эмзэг турьхан гэсэн гунигт мэдрэмж л төрнө. Үүнийг зургийн хөнгөн хэр нь уйтгарт өнгө улам бүр тодотгох ажээ.

Зураг 1

Б. Хонгорзул. Цагаан эрвээхэй. 2003



Зураач Ж.Мөнхцэцэг эмэгтэй хүнийг дур булаам уруул, хэлбэр сайтай хөх, булбарай зөөлөн арьс, царайлаг төрхөөр хязгаарлан зөвхөн гадаад гоо сайхныг дагнан дүрсэлдэг тогтсон хэв маягийг өөрчилж, харин ч эсрэгээр нь эмэгтэй хүний дотоод ертөнц рүү чиглэж, огт өөрөөр дүрсэлдэг. Тэрээр сүүлийн үеийн бүтээлүүддээ өөрийн гэрэл зургаа ашиглаж, бал, харандаа, коллаж гэх мэтийг ашиглан холимог арга техникээр ажиллаж байна. Бүтээлдээ фото хайчилбар ашиглаж, өөрийн нүүр царайгаа ил тод гаргах болсон нь зарим талаар түүнийг илүү чөлөөлсөн гэлтэй. Тэрээр бүтээлдээ эмэгтэй хүнийг дүрслэхдээ дотор эрхтнүүдийг, ялангуяа бэлгэ эрхтэн, өндгөвч, сав зэргийг маш тодоор дүрсэлсэн байна. Түүний “Нам гүм” хэмээх цуврал бүтээлийг авч үзье. Энэ бүтээлд зураач мөн л өөрийнхөө фото зургийг ашиглажээ.

Цувралын нэгдүгээрт эмэгтэйд нууц эрхтнээ дэлгэн сууж буйгаар дүрсэлж, хоёр хөхийг цагаан өнгийн цэцгээр, өвдгөвчийг улаан өнгийн цэцгээр илэрхийлж, зулайгаас биеийг таллан хуваасан тод улаан зураасаар өндгөвчийг холбожээ. Харин хоёрдугаар зурагт эмэгтэйд төрч буйгаар дүрсэлжээ. Үр удам өсөж бойжих савыг алтлаг өнгөөр дүрсэлж, хүүхэд юу юугүй мэндлэх гэж байгааг үзүүлжээ. Өмнөхөөс ялгаатай нь төрж буй эмэгтэй нүүр болон үсийг улаан өнгөөр дүрсэлсэн байх юм. Гуравдугаар зурагт эмэгтэйн биеийг олон гар хөлтэй бөгөөд биеийн хөдөлгөөн байдал бодит бус нугаларсан байдлаар дүрсэлж, бараан саарал өнгийг түлхүү ашиглажээ. Зураач тус бүтээлдээ эмэгтэй хүний гоо сайхны мөн чанарыг маш доторлог байдлаар, мөн маш зоримог илэрхийлжээ.

Бүтээлд уран нарийн дүрслэл, тансаг өнгийн зохицлыг ашиглаагүй ч эмэгтэй хүний

ертөнцийн эгэлгүй хэрнээ агуу мөн чанарыг гүн гүнзгий тусгаж харуулжээ. Энэ бүх зовлон жаргалыг биеэр мэдэрч, сэтгэлээр туулсны хувьд, “эмэгтэй хүнийг дүрсэлсэн эр хүний ямар ч яруу тансаг бүтээлээс түүнийх шиг ийм нарийн нандин, дотоод ертөнцийн мэдрэмжийг бид олж харж чадахгүй” биеэ (Уранчимэг, 2018, х.93-98).

Зураг 2

Ж.Мөнхцэцэг. Нам гүм. 2009



Эмэгтэй хүний дотоод ертөнцийг өөрийн гэсэн өвөрмөц өнгө аясаар дүрсэлдэг өөр нэгэн зураач бол залуу зураач Ж.Анунаран юм. Түүний бүтээлийн гол дүр нь тэр өөрөө. Тийм ч учраас түүний бүтээлийн утга санаа, хэллэг нь бусдаас онцгойрдог юм.

Ж.Анунаран мөн л өөрийнхөө фото зургийг бүтээлдээ ашиглаж, коллаж, тосон будгийн холимог техникээр ажилладаг.

“Аливаа цаг үе, нийгмийн байдал тухайн үеийн уран бүтээлчийн сэтгэлзүй, уран бүтээлд нөлөөлж байдаг нь илэрхий. Гагцхүү тэр цаг үе, нийгмийн байдлыг хэрхэн хүлээж авч, яаж илэрхийлэх нь уран бүтээлчийн сэтгэлгээнд суурилдаг” (Анунаран, 2016, х.183). Зураач амьдралаас олсон сэтгэл хөдлөл, мэдрэмжээ өөрийн бие махбодын хөдөлгөөнөөр илэрхийлдэг.

Эхийнхээ хэвлийд нойрсож буй хүүхдийг эхо аппаратаар харж буй мэтээр дүрсэлжээ. Тодорхой нэгэн бичил орон зайд атиралдсан, эвхрэлдсэн хөдөлгөөн элдэв хөдөлгөөн нь харилцан адилгүй сэтгэл хөдлөлийг илтгэнэ. Далайн ёроолд уусах мэт гүн хөх цэнхэр өнгө хараа булааж, эхо аппаратаар нэвт харах мэт гэрэл сүүдрийн солбилцол нь түлхэх мэт сэтгэгдэл төрүүлнэ.

Өнгө болон гэрэл сүүдрийн шийдэл нь анхаарлыг татах хэрнээ түлхэнэ. Энэ тогтворгүй байдлын дунд алгуур тайвнаар хөвөх мэт эмэгтэйн биеийг танан өнгөт цэцгээр хааж, цэцэгсийн дэлбээд таран хөвж, соно эргэлдэн нисэх нь нүд эрээлжилж, толгой эргэм өнгө гэрлийн хурц шийдлийг зөөлрүүлж, эмэгтэй хүний дотоод сэтгэлийн зөрчилт байдлыг үзэгчид биеэр мэдрүүлэх мэт ажээ.

Зураг 3

Ж.Анунаран. Зохиомж. 2017



Судлаач миний бие дээрх зураачдын бүтээлд анализ хийсний үндсэн дээр “Хүсэл” нэртэй зургийг зурлаа. Өөрийн дотоод ертөнц, туулж өнгөрүүлсэн амьдрал, ирээдүйн тухай сайн сайхан хүсэл тэмүүлэл элдэв гоёчлолгүй хэрхэн илэрхийлж гаргах тухай бодлууд хөвөрсөөр, тэдгээрийг хамгийн энгийн, хамгийн өөрт ойр тэмдэг дүрсээр илэрхийлэх л гарцаагүй тулгарч ирлээ.


Эмэгтэй хүний гоо сайхнаа тодотгох хамгийн гол хэрэгсэл болдог. Тиймээс ч эмэгтэй хүний үс гэзгээ янзлах, гоёж чимэглэсэн байдлаас түүний дотоод сэтгэл, хүсэл тэмүүлэл, сэтгэл санааны байдлыг харж болдог. Үс гэзгээр дотоод сэтгэлийг илтгэсэн дүрслэл Ж.Мөнхцэцэг зэрэг олон эмэгтэй зураачдын бүтээлд өргөн ажиглагддаг. Үүнээс санаа авч үелэн давалгаалах уул толгод мэд намиран хийсэх үсээр өөрийнхөө хүсэл мөрөөдлийн зам, замд тохиох олон даваа гүвээг төлөөлүүлж, тэдгээр даваа гүвээдийн дээгүүр салхин зүсэн хурдлах улаан зүсмийн морьдыг зурлаа. Улаан өнгө хүсэл тэмүүлэл, эр зоригийг бэлгэж, хүсэл мөрөөдлийн минь алс хэтийг гэрэлтүүлнэ.

Моринд хайртай монгол хүний ёсоор өөрийн өсч дэвжих, сайн сайхан явахыг ямагт хээрийн салхинд дэл сүүлээ намируулсан тааваар давхих

хөнгөн туурайтаар төсөөлдөгсөн. Намиран дэрвэлзэх галт дэл сүүл бүхий улаан хүлэг морьд нь ирээдүйн төлөөх хүсэл мөрөөдөл, гал одтой тэмцлийн замыг бэлгэдэнэ.

Зураг 4

Ш.Өрлөг. Хүсэл. 2019



Дүгнэлт

Урлагийн түүхэнд эмэгтэй хүний гадаад гоо сайхныг магтан дуулсан, бодит дүрслэлийн уран зураг ихээхэн цаг хугацаа, орон зайг эзлэх боловч, орчин үед эмэгтэй ертөнцийн дотоод гоо, амьдралынх нь мөн чанар, утга агуулгын гүнд чиглэсэн сэтгэлгээний өнгө аяс бүхий уран зургийн хэв маяг давамгайлах болжээ.

Орчин үед зураачид эмэгтэй хүнийг дүрслэх академик хэв загвараас зайлсхийж, тэдний дотоод ертөнц, түүнд орших жинхэнэ эмэгтэй гоо сайхныг илэрхийлэхийг чухалчлах болсон зураачдын бүтээлээс тод харагдаж байна.

Эрэгтэй зураачид эмэгтэй хүнийг уран зурагт дүрслэхдээ гоолиг сайхан бие цогцос, уран тансаг биеийн хөдөлгөөн, тансаг чамин байдлаар илтгэдэг бол эмэгтэй зураачид ихэд өвөрмөц ялгаатай, дотоод ертөнцийн гүнд чиглэсэн сэтгэлгээний өнгө аястайгаар илтгэдэг онцлог орчин үеийн уран зурагт улам тодоор илрэх болжээ. Энэ нь уран зургийн сэдэв агуулахуун хүний дотоод сэтгэлийн гүн гүнзгий өнгө аясыг эрэлхийлж, дүрс дүрслэл нь бэлгэдлийн шинж

тийш улам бүр хандаж буйн нэгэн илрэл юм.

Миний бие Монголын орчин эмэгтэй зураачид уран зураг дахь эмэгтэй хүнийг дүрсэлж буй онцлогийг судалсан үр дүнд үндэслэн өөрийн зурж ирсэн хэв маягт шинэ алхмыг хийж, сэтгэлгээ, арга барилын хувьд өвөрмөц өнгө аясыг бүтээлдээ гаргалаа.

Ном зүй

Анунаран, Ж. (2016). *Модерн уран зурагт уран бүтээлчийн итгэл илрэх нь. Монгол судлал сэтгүүл.*

XXXX боть. Улаанбаатар. Х.181-188

Санжмятав, Т. (1995). *Монголын хадны зураг.* Улаанбаатар

Цүлтэм, Н. (1988). *Монголын уран зургийн хөгжиж ирсэн тойм.* Улаанбаатар

Уранчимэг, Ц. (2002). *XX зууны өрнөдийн урлаг.* Улаанбаатар

Уранчимэг, Ц. (2018). *Монголын дүрслэх урлаг судлалын түүвэр нийтлэлүүд.* Улаанбаатар

Female images in the works of Mongolian modern painters

Wuriluge.Sh*

Department of Education School,
Primary Education, Hulunbuir University

Abstract

Many types of topic are animated in the fine art history of the humanity. Female characters' art especially female beauty praise is one of many beauty symbols expressed by artists time to time. All the beauty, expressed with female beauty characters in fine art is created in combination with paints and brushes all the time and created fine art history from the very first time to the present.

In modern fine art, it is not preferred to express female beauty with academic imagination style and preferred to emphasize to express female's unseen and internal beauty more. Modern Mongolian female artists are succeeded in a new step of female beauty expression in their fine art and creation of unique and special nuance for their orientalism and method. Fine art expresses female beauty by female artists are considerably differed than fine art by male artists, shows female internal beauty ideally and promoting unique and special imagination of female beauty in fine art.

Keywords

Art, traditional, aesthetics, image, female painter, yin and yang

* Corresponding author: 276261579@qq.com